

ТАНИЛЦУУЛГА

“Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын төслийн тухай

Монгол Улсын Их Хурлаас 1999 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар заасан.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 55 дугаар тушаалаар баталсан журмаар дундаж цалин хөлсийг тодорхойлохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 2-ний өдрийн хуралдаанаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан бөгөөд уг хууль 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд цалин хөлсний зарчим, бүрэлдэхүүн, тогтолцоотой холбоотой шинэ зохицуулалтууд тусгагдсан. Үүнд:

- Цалин хөлс тогтооход баримтлах зарчмыг шинэчлэн тогтоох, цалин хөлс тогтооход төрийн оролцоог багасгаж хөдөлмөр, нийгмийн зөвшлийн талууд, салбарын мэргэжлийн холбоод оролцох байдлаар зохицуулах;

- Илүү цаг, шөнийн цаг, нийтээр амрах баярын өдөр болон долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс болон хөдөлмөрийн чадвараа алдсаны, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйг өөр ажилд шилжүүлсний, гэрч, хохирогчийн хамгаалалтад байгаа ажилтны, сул зогсолт, богиносгосон цагаар ажиллах, хөдөлмөрийн норм биелүүлээгүй үеийн олговрын хэмжээг хуулиар тогтоож бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, олговор, түүний хэмжээг хамтын гэрээ, дотоод хэм хэмжээгээр тохиролцон олгох;

-Ээлжийн амралтын олговрыг ээлжийн амралтын цалин болгож, цалин хөлсний бүрэлдэхүүнийг үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал, урамшууллаас бүрдэхээр тогтоох зэрэг байна.

Мөн дундаж цалин хөлснөөс тооцож ажилтанд олгох нэмэгдэл хөлс, олговор, нөхөн төлбөр, тэтгэмжийн төрөл, зүйлд шинэ зохицуулалтууд, холбогдох нэмэлт, өөрчлөлтүүд орсон. Тухайлбал: Илүү цагаар, шөнийн цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баярын өдрөөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг дундаж цалин хөлснөөс тооцож олгох, дундаж цалин хөлсийг тооцох цалин хөлсний бүрэлдэхүүнд ээлжийн амралтын цалинг оруулах гэх мэт.

Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.1-т “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан тул хуулийн хэрэгжилтийг хангах, тусгагдсан шинэ зохицуулалтуудыг нарийвчлан зохицуулах хүрээнд тус журмын төслийг боловсрууллаа.

Журмын төсөл Нийтлэг үндэслэл, Дундаж цалин хөлс тодорхойлох гэсэн хоёр бүлэгтэй ба хуулийн холбогдох заалтуудыг нарийвчлан тодотгож жишээ, тайлбарыг оруулж дараах байдлаар тусгасан.Үүнд:

- ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүн, нэр томъёог тодорхойлж тайлбарлах;
- илүү цагаар, шөнийн цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баярын өдрөөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг олгохтой холбоотойгоор дундаж цалин хөлсийг тодорхойлох;
- Хөдөлмөрийн тухай хуульд заасан олговор, тэтгэмж, нөхөн төлбөрийг тооцоход дундаж цалин хөлсийг хэрхэн тодорхойлох;
- ажилтны цалин хөлснөөс суутгал хийж хохирлыг нөхөн төлүүлэх, ажилтанд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд дундаж цалин хөлсийг хэрхэн тодорхойлох;
- ажилтны ажилласан хугацаа дундаж цалин хөлс тооцохоор заасан хугацаанд хүрэхгүй тохиолдолд дундаж цалин хөлсийг хэрхэн тодорхойлох зэрэг болно.